



**Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
хурлаас гарсан өмч хөрөнгөтэй
холбоотой тогтоолын хэрэгжилт**





2016.09-2017.09 хооронд өмч хөрөнгөтэй холбоотой 36 тогтоол гарсан







Хэрэгжилтийн явц





Хөрөнгө актлах





2016.09-2017.09 хооронд давхардсан тоогоор 29 байгууллагын 966,8 сая төгрөгийн хөрөнгийг 8 тогтоолоор акталсан байна. Хэрэгжилт 93,75% хувьтай байна

- Үүнээс удаашралтай байгаа тогтоол нь 2017.09.27 өдрийн 70 дугаар тогтоолоор актлагдсан Тэлмэн сумын ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй халуун усны барилгыг буулгаж 2017 оны жилийн эцсээр данс бүртгэлээс хасахаар ажиллаж байна. Мөн Тосонцэнгэл сумын ЗДТГ-т бүртгэлтэй УАЗ-31512-аас 200,000 төгрөг, Starex-аас 500,000 төгрөг, Rexton-оос 100,000 доошгүй төгрөгийн сэлбэгийг зарж борлуулж төсөвт оруулахаар ажиллаж байна.



Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх





2016.09-2017.09 хооронд давхардсан тоогоор 11 байгууллагын 193,9 сая төгрөгийн хөрөнгийг 8 тогтоолоор Балансаас балансад шилжүүлсэн байна. Хэрэгжилт 98,75 хувьтай байна.

Удаашралтай байгаа тогтоол: 2017.09.27 өдрийн 69 дүгээр тогтоолоор Эрдэнэхайрхан, Нөмрөг, Тэлмэн, Тэс, Баянтэс сумдын ЭМТ-д ашиглаж байсан автомашинуудыг Уламжлалт анагаах ухааны төв, Зооноз өвчин судлалын төв, Нэгдсэн эмнэлэг, Баянтэс сумын ИТХ-д 2017.10.02 өдөр Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтнүүд жолооч эмч нарт нь хүлээлгэн өгсөн. Дөрвөлжин сумын Эрүүл мэндийн төв автомашинаа хүлээж аваагүй байна.



Хөрөнгө бэлтгэх





2016.09-2017.09 хооронд 5 байгууллагын 55,98 сая төгрөгийн хөрөнгийг 4 тогтоолоор бэлтгэсэн байна.

- Хувь
- Хэрэгжсэн хувь



Хөрөнгийн доод үнэ тогтоох





2016.09-2017.09 хооронд 15 байгууллагын 21 нэр төрлийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах шийдвэр гарч 10 байгууллагын 11 нэр төрлийн хөрөнгийг худалдан борлуулсан. Өмч хувьчлалын дансанд нийт 43,8 сая төгрөгийн орлого оруулаад байна.

Удаашралтай байгаа тогтоол: 2017.09.27 өдрийн 68 дугаар тогтоолоор 10 байгууллагын 15 нэр төрлийн хөрөнгийг худалдах шийдвэр гарсан. Завхан сонины 2017.09.29 өдрийн дугаарт зар тавьж 10 сарын 31-ны өдөр дуудлага худалдааг зохион байгуулж Идэр сумын ЭМТ эмчийн орон сууц, Цагаанхайрхан сумын ЗДТГ Конторын хуучин барилга, айлын орон сууц, Дөрвөн оноо өрхийн эмнэлгийн хуучин барилга Алдархаан сумын ЭМТ УАЗ-31512, Сантмаргаз сумын ЭМТ УАЗ-31512 хөрөнгөнүүдийг худалдан борлуулж орлогыг өмч хувьчлалын дансанд оруулсан. Зарагдаагүй үлдсэн 6 байгууллагын 9 нэр төрлийн хөрөнгийн дуудлага худалдааг 2017.12.12 өдөр зохион байгуулахаар ажиллаж байна.



Өмч хөрөнгөтэй холбоотой бусад тогтоол



1. Орон сууцыг бусдын өмчлөлд шилжүүлэх
2. Тогтоол хүчингүй болгох
3. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар байгуулах тухай
4. Ажлын хэсэг байгуулах тухай
5. Тооллогын дүн батлах тухай
6. Тээврийн хэрэгсэл бусдын өмчлөлд шилжүүлэх тухай
7. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын нэр өөрчлөх тухай
8. Үнэ тогтоох комисс шинэчлэн батлах тухай
9. Тогтоолын хавсралтын зарим хэсгийг хүчингүй болгох тухай
10. Тогтоол хүчингүй болгох тухай
11. Орон нутгийн өмчийн тухай
12. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журмыг шинэчлэн батлах тухай
13. Хөрөнгө бүртгэлд авах тухай

Анхаарал тавьсанд баярлалаа

